

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРВАН НЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны гуравдугаар сарын 31-ний 14 цаг 03 минутад эхэлж, 14 цаг 19 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 16 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Журамд өөрчлөлт оруулах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-д өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 31 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>“Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институтын санхүүд” гэснийг “Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд” гэж, 9.4 дэх хэсгийн “Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институт” гэснийг “Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба” гэж, 9.5 дахь хэсгийн “Төрийн албаны институт” гэснийг “Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба” гэж тус тус өөрчлөх тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Батлан хамгаалах яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах</p>

		<p>журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Батлан хамгаалах яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Төрийн нарийн бичгийн дарга /Салбар зөвлөлийн дарга/</li> <li>2) Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга,</li> <li>3) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,</li> <li>4) Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,</li> <li>5) Гадаад хамтын ажиллагааны газрын дарга,</li> <li>6) Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга,</li> <li>7) Яамны хуулийн зөвлөх,</li> <li>8) Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга,</li> <li>9) Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийн бодлогын мэргэжилтэн /Нарийн бичгийн дарга/</li> </ol> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 6 дахь хэсгийг хүчингүй болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА